



МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2021-02-02 № 05/1433
танай _____-ны № _____-т

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай


Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын албаны даргын албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Баатарын Ганзориг, мөн газрын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үндэсний зөвлөлийн ажлын албаны Эрүүл мэнд боловсролын асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Сүхбаатарын Эрдэнэчимэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Батбаатарын Батцэцэг, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Төмөр замын зураг төсөл, хиймэл байгууламж хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн Уртнасангийн Эрдэнэбаатар нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч Б.Ганзориг нь Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2, 33.3-т заасны дагуу төрийн албаны тусгай шалгалт /албан тушаалын/ өгөөгүй байх тул төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох эрх зүйн зохицуулалтыг баримтлан тухайн албан тушаалд томилох эсэх асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй.

Нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д зааснаар Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно гэж заасныг болон хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлэн, аливаа авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах нь зүйтэй.

Түүнчлэн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргахыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ
ДАРГА, АХЛАХ КОМИССАР



Л.СҮХ-ОЧИР

0004035